



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/459

Есөнбулаг

Төв суурин газрын өвөлжилтийн  
бэлтгэлийг хангах ажлын хэсэг байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн хэмжээнд 2023-2024 оны төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргаж, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулж хэрэгжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Чинбат)-д даалгасугай.

3.Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, хамтран ажиллахыг албан байгууллагын дарга, захирал, эрхлэгч, сумдын дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20... оны  
... дугаар сарын ...-ны өдрийн .... дугаар  
захирамжийн хавсралт

**ТӨВ СУУРИН ГАЗРЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ  
ХАНГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: -Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн дарга

Гишүүд:

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

-Онцгой байдлын газрын дарга

-Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

-Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

-“Алтай-Улиастайн Эрчим Хүчний систем” ТӨХК-ийн  
гүйцэтгэх захирал

-“Ундарга-Алтай” ААТҮГ-ын захирал

-“Солонго дулааны станц” ААТҮГ-ын захирал

-“Мандал-Голомт” ХХК-ийн захирал

-“ГАА-АЗЗА” ТӨХК-ийн захирал

-Сумдын Засаг дарга нар

-Сумдын дулаанаар хангагч байгууллагууд